

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

___ оны ___ сарын ___ өдөр

Дугаар _____

Улаанбаатар хот

Тэтгэвэр авах дундаж хугацааны
илэрхийлэл тогтоох тухай

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны 2018 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн дүрэм”-ийн 5 дахь хэсгийн 5.1.3 дахь заалт, Үндэсний статистикийн хорооны 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 01/957 тоот албан бичгээр ирүүлсэн саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгоход баримтлах тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл (“К”)-ийг 2022-2024 онд эмэгтэй даатгуулагчид 22 жил 7 сар, эрэгтэй даатгуулагчид 15 жил 7 сараар тус тус тогтоосугай.

2. Энэ тогтоолоор баталсан тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр бодоход баримтлахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Д.Зоригт)-т даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба (Г.Банзрагч) -нд үүрэг болгосугай.

ДАРГА

А.АРИУНЗАЯА